



Хүүхдийг Ивээх Сан (Япон)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

Хүүхдийн Ивээх Сан хүүхэд бүрийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг дэлхий нийтээр хангуулахын төлөө ажилладаг. Гэрэлт ирээдүйнх нь төлөө хүүхдүүдийг хамгаалах, тэдний дуу хоолойг сонсох, сайн сайхан байдлыг хангах нь бидний үндсэн үүрэг хариуцлага билээ.

Дэлхий улс орнуудад болон Япон, Монгол аль ч улсад хүүхэдтэй зүй бусаар харьцах, мөлжих үзэгдэл байсаар байна. Хүүхэдтэй зүй бус харьцах үзэгдэл гэр бүл хийгээд хүүхдийн харьяалагдах олон нийтийн орчинд ч гарч байна. Хэний ч аюулгүй байдал баталгаагүй дэлхий ертөнцөд бид амьдарч байна. Түүнчлэн, орчин үеийн техник технологийн хөгжил цахим харилцааны асуудал, зүй бус зураг дүрс гэх мэт шинэ төрөл, хэлбэрийн аюул заналыг үүсгэж байна.

Өөрт буй эрх мэдлээ ашиглан хүүхдэд ямар нэг сөрөг нөлөө санаатайгаар учруулахыг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй. Тиймээс Хүүхдийг Ивээх Сангийн ажилтнууд, түншлэгчид, бусад төлөөлөгчид хүүхэдтэй зүй бус харьцах бүх хэлбэр болон бэлгийн мөлжлөгийг үл тэвчих хандлагыг баримталдаг. Хэрэв энэхүү хандлагыг зөрчих аваас дэмжигчдээ хууран мэхэлсэн, тэдний итгэлийг алдсан хэрэг болох бөгөөд хүүхдүүд, тэдний гэр бүлд ноцтой хор хохирол учруулна.

Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвсэл 2010 онд “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах протоколь”-ийг баталж, үүнд хүүхдэд ээлтэй байгууллага болохын хувьд ажилтан бүр мөрдвөл зохих тодорхой стандартуудыг тусгасан байдаг. Эвслийн гишүүн орны хувьд Японы Хүүхдийг Ивээх сан энэхүү протоколийг мөрдөхөд бүхий л талын хүчин зүтгэл гаргана. Хүүхдийн аюулгүй байдал гэдэг бол хүүхдийг бүх хэлбэрийн зүй бус харьцаа, мөлжлөгөөс хамгаалах бидний нийтлэг үүрэг хариуцлага юм. Бүх ажилтан, биднийг төлөөлж буй хүн бүр эрсдэлийг бууруулах чиглэлээр шаардлагатай бүх арга хэмжээг авах, ямар нэг шинж тэмдэг, сэжиг бүхий мэдээллүүдэд дээд зэргээр сонор соргог хандах ёстой. Хувь хүний хийгээд байгууллагын хүчин зүтгэл, практик үйл явц нь бидний өдөр тутмын ажил болон хүүхэдтэй хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд чухал үүрэгтэй.

Хүүхдийг Ивээх Сангийн гишүүн бүр хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, ёсзүйн дүрэмтэй байна гэж протокольд заасан байдаг. Тиймээс Японы Хүүхдийг Ивээх Сан 2014 онд Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвслийн боловсруулсан “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого”-ыг орчуулж, зарим өөрчлөлт оруулан, энэхүү бодлогыг гаргав. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилго, байгууллага хийгээд хувь хүн, түншлэгчийн

гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг энэхүү бодлогод тусгасан болно. Бодлогын хоёр болон дөрөвдүгээр бүлэг нь Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвслийн “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого”-д заасантай үндсэндээ адил бөгөөд нэг, тав, зургадугаар бүлэгт Японы Хүүхдийг Ивээх Сангийн Япон болон Монгол улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд хамаарах зүйлийг нэмж тусгалаа.

БҮЛЭГ 2. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Бидний үйл ажиллагааны үр дүнд Хүүхдийг Ивээх Сантай холбогдож буй бүх хүүхэд зүй бус харьцаа, бэлгийн мөлжлөг, осол гэмтэл, бусад ямар нэг хор хөнөөл үзүүлэхүйц санаатай хийгээд санамсаргүй зөрчил, үйлдлээс бүрэн хамгаалуулах ёстой. Энэхүү үүрэг хариуцлага манай байгууллагын бүх ажилтан, албан хаагчид хамаатай бөгөөд бусад бодлого, дүрэмтэй уялдсан байдаг.

Бодлогын хүрээнд дараах зүйлийг шаардана:

- Хүүхдийг Ивээх Сан хүүхэдтэй ажиллах шаардлага хангасан хүнийг ажилд авах бөгөөд ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг бүрэн тусгана.
- Байгууллагатай холбоотой хүн бүр үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаж, хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн мөлжлөг үйлдэх асуудалд зохих арга хэмжээ авах чадвартай байна.
- Байгууллагыг төлөөлж буй хүн бүр хүүхэдтэй зохих ёсоор харьцах, Хүүхдийг Ивээх Сан гэх нэгэн том гэр бүлийн гишүүн болохын хувьд олж авсан итгэл, эрх мэдлээ хүүхэдтэй зүй бус харьцахад ашиглахгүй байх ёстой.
- Байгууллагыг төлөөлж буй хүн бүр манайхтай харилцаатай хүүхдүүдэд аюулгүй орчин бүрдүүлэхэд идэвх санаачилгатай ажиллана.
- Байгууллагаас хэрэгжүүлж буй бүхий л хөтөлбөр, үйл ажиллагаа, хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүд хүүхэдэд учирч болох эрсдэлүүдийг урьдчилан үнэлэх, тэдгээрийг арилгахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах учиртай.
- Хүүхдийг Ивээх Сангийн төв, бус, улс орны салбарууд хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох бүхий л хүний ойлголтыг нэмэгдүүлэх, хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлж, түүний дагуу ажиллана.
- Дээр дурдсан арга замаар Хүүхдийг Ивээх Санг хүүхэдэд аюулгүй байгууллага болгож, хүүхдийн эрх, өөрсдийн зорилго тэмүүлээ хүндэтгэж байгаа хэрэг юм.

БҮЛЭГ 3. ЗАРЧИМ

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого дараах зарчмуудыг мөрдлөг болгоно:

- **Хувь хүний хариуцлага.** Японы Хүүхдийг Ивээх Санг төлөөлж буй хүн бүр ажил мэргэжил хийгээд хувийн амьдралдаа хүүхэдтэй харьцах зан үйлийн дээд зэргийн стандартыг баримтална. Ажилтан нэг бүр энэхүү бодлогыг сайтар ойлгож, дэмжин хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Түүнчлэн, ажилтан нэг бүр энэхүү бодлогыг ямар нэг хэлбэрээр зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд мэдээлэх, зохих хариу арга хэмжээ авах чиглэлээр бүхий л талын хүчин зүтгэл гаргана.
- **Олон талт чанар.** Хаана, ямар үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран Японы Хүүхдийг Ивээх Сангийн бүхий л ажил, түүнийг гүйцэтгэж буй ажилтан бүрт хамаатай албан ёсны шаардлагыг энэхүү бодлогоор тавьж байна.
- **Стандартад суурилсан хандлага.** Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн аюулгүй байдлыг хангах стандартад суурилсан хандлагыг мөрддөг. Манай байгууллагын аюулгүй

байдлын болон ажилтны зан үйлийн стандартууд нь тухайн улс орны хууль журам, уламжлал, зан заншлын хэм хэмжээнээс ямагт өндөр байна. Хүүхдийг Ивээх Санд нэгдсэн хэн боловч тэдгээр стандартыг хүлээн зөвшөөрөх бөгөөд даган мөрдөх учиртай.

- **Нээлттэй байдал.** Хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой ямар нэгэн санаа зовоосон зүйл, асуудлыг гарган тавих, хэлэлцэх орчныг бүрдүүлэхийг зорино.
- **Ил тод байдал, хариуцлага.** Хүүхдийн эсрэг гарч болох сөрөг зан үйлийг арилгах, муу туршлагыг халах, сайн туршлага, санаачилгыг дэмжих нь чухал.
- **Хүүхэд, түүний хүрээллийн өмнө хүлээх хариуцлага.** Байгууллагын дотоод тогтолцоо, стандарт, практик туршлагаа сайжруулах замаар үйлчилж буй хүмүүсийнхээ өмнө илүү хариуцлагатай байж чадна.
- **Хүүхдийн оролцоо, үл ялгаварлал.** Оролцоо, үл ялгаварлалтай холбоотой эрхээ хүүхдүүд мэддэг байх, юуг хүлээн зөвшөөрөх, юуг үл хүлээн зөвшөөрөх, ямар нэг санаа зовоосон зүйл, асуудал гарвал юу хийх ёстой талаар хүүхдүүдэд ойлгуулах ёстой.
- **Хүүхдийн дээд эрх ашиг.** Хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллахдаа хүүхдийн дээд эрх ашгийг эн тэргүүнд харгалзах бөгөөд хүүхдийн сэтгэл санаа, сэтгэлзүй, биемахбодын хэрэгцээг агуулсан аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахыг ямагт эрмэлзэнэ.
- **Нууцлал.** Хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой зөрчил, мэдээлэл, шалгах үйл ажиллагаа нь зөвхөн мэдэх шаардлагатай зүйлийг л асуух зарчмаар хэрэгжих бөгөөд үүнтэй холбогдох бүхий л мэдээллийг нууцална. Үүнтэй адилаар, энэ асуудалтай холбоотой бүхий л харилцаа нууц бөгөөд аюулгүй байна.
- **Цаг хугацаа.** Зүй бус харьцааны нэмэгдэх хийгээд давтагдах магадлалыг харгалзан үзсэний үндсэн дээр хариу арга хэмжээг цаг алдалгүй авах нь тун чухал. Зөрчлийг мэдээлэх, хариу арга хэмжээ авахад зарцуулах цаг хугацааны хязгаарыг тодорхой болгох хэрэгтэй.
- **Тохироо.** Энэхүү бодлого нь Хүүхдийг Ивээх Сангийн холбоо, Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвслийн 2010 онд баталсан Хүүхдийн аюулгүй байдлыг хангах протоколь, 1989 онд баталсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, 2003 онд гарсан бэлгийн мөлжлөг, зүй бус харьцаанаас хамгаалах тусгай арга хэмжээний тухай НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөмж, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсын Хүмүүнлэгийн тусламжийн хорооны холбогдох бичиг баримт болон тухайн улс орны хууль тогтоомжтой тохирсон байна.
- **Үйлчлэл.** Энэхүү бодлого ажлын болон ажлын бус цагийн аль алинд хамаатай.
- **Тэргүүн зорилго.** Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар манлайлагч болохоо илтгэн харуулах чиглэлээр ажиллана.
- **Түншилэл.** Байгууллага дотроо хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гадна орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр бусад агентлагуудтай түншилнэ.

БҮЛЭГ 4. ТОДОРХОЙЛОЛТ

Нэр томьёо	Тодорхойлолт
Хүүхэд	18-аас доош насны бүх хүнийг хүүхэд гэж үзнэ.
Хүүхдийн аюулгүй байдал	Энэхүү нэр томьёо нь Хүүхдийг Ивээх Сан хүүхдэд аюулгүй байгууллага байх хүрээнд хэрэглэх бодлого, дүрэм, үйл ажиллагааны цогцыг илэрхийлдэг. Байгууллагын хэн нэг ажилтан санаатайгаар өчүүхэн төдий алдаа гаргахад хүүхдэд сөрөг нөлөө учирч болохыг бид бүгд мэддэг байх ёстой. Тиймээс иймэрхүү зан үйл, хандлагыг үл хүлээн зөвшөөрч,

	<p>үүнээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бодлогоо хэлбэрэлтгүй мөрдөх учиртай. Манай байгууллагатай холбоотой хэн боловч хүүхэдтэй зүй бус харьцах, бэлгийн мөлжлөгийн талаар сайтар ойлгож, иймэрхүү асуудал гарвал зохих хариу арга хэмжээ авах үүрэгтэй. Манай байгууллагыг төлөөлж буй хэн боловч ажил хийгээд хувийн амьдралын аль ч талбарт хүүхэдтэй зохистой харьцах, Хүүхдийг Ивээх Сан гэсэн өнөр өтгөн гэр бүлийн гишүүн болоход дагалдан ирдэг тэрхүү итгэлийг далимдуулан хүүхэдтэй зүй бус харьцаж үл болно.</p> <p>Аливаа зүйлд анхаарал болгоомжтой хандаагүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалттай аваагүй болон бидний гаргаж болох бусад алдаа дутагдал таамаглаагүй сөрөг нөлөөг үүсгэж болзошгүйг мартаж болохгүй. Түүнчлэн, урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой зөрчил ч гарч болно. Бидний хөгжлийн хийгээд хүмүүнлэгийн төлөөх үйл ажиллагаа, хөрөнгө босгох, нөлөөллийн компанит ажлуудын явцад гарч байсан иймэрхүү үйлдлийн жишээ олон. Тиймээс аюулгүй байдлыг хангах хандлагыг хөтөлбөрийн төлөвлөлт болон хүүхэдтэй холбогдох бүхий л үйл ажиллагаанд тусгах нь эрсдэлийг бууруулах, улмаар арилгах өгөөжтэй арга юм.</p> <p>Өөрөөр хэлбэл, хүүхдийн аюулгүй байдал, халамж хамгааллыг баталгаажуулах үүднээс бидний зүгээс чадах бүхнээ хийх оролдлого, хүчин зүтгэлийг аюулгүй байдлыг хангах гэж ойлгоно.</p> <p>Хүүхдийн эрхийг түүний амьдарч буй орчин тойронд хангах нь баттай суурь билээ. Зарим байгууллага хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг “хүүхэд хамгаалал” гэсэн нэр томъёогоор илэрхийлэн хэрэглэж байна. Харин манай байгууллагын хувьд энэхүү асуудлыг хүүхэд хамгааллын өргөн хүрээний үйл ажиллагаанаас ялган салгахын тулд “хүүхдийн аюулгүй байдлыг хангах” гэсэн нэр томъёог хэрэглэж байгаа бөгөөд энэ нь ч давуу талтай болох нь мэдэгдэж байна. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2003 оны зөвлөмжид тусгаснаар “Бэлгийн мөлжлөг, зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэх” гэсэн нэр томъёог хэрэглэдэг.</p>
<p>Хүүхэдтэй зүй бус харьцах</p>	<p>Хүүхэдтэй зүй бус харьцах гэдэгт хувь хүн, байгууллага, ажлын шат дарааллаас хамааран гарах хүүхдэд шууд хийгээд шууд бус байдлаар хор учруулах, эрүүл саруул, хэвийн хөгжилтэй насанд хүрсэн иргэн болон төлөвших үйл явцад саад болохуйц үйлдэл, эс үйлдэл багтана.</p> <p>Хүүхэдтэй зүй бус харьцах хэлбэрүүдийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас биемахбодын зүй бус харьцаа, сэтгэл санааны зүй бус харьцаа, үл хайхрах, хайхрамжгүй хандах зүй бус харьцаа, бэлгийн зүй бус харьцаа, мөлжлөг гэж ангилсан байдаг.</p> <p>Бие махбодын зүй бус харьцаа гэдэг нь биеийн хүчээ ашиглан хүүхдийн биемахбодод гэмтэл учруулах эсвэл өвтгөж зовоох (цохих, сэгсрэх, түлэх, эм бэлэг эрхтнийг эрэмдэглэх, тамлах гэх мэт)-ыг хэлнэ.</p>

	<p>Сэтгэл санааны буюу сэтгэлзүйн зүй бус харьцаа нь хүүхдийг хочилж дуудах, байнга шүүмжлэх, дорд үзэх, ичээх, ганцааранг нь байлгах, хорих, ганцаардуулах гэх мэт хүүхдийг доромжлон гутаасан бүхий л үйлдлийг хэлнэ.</p> <p>Үл хайхрах зүй бус харьцаа гэдэг нь тогтмол эсвэл ноцтой байдлаар хүүхдийг хайхрах, даарах, өлсөх зэрэг аюулаас үл хамгаалах, хүүхдийн эрүүл мэнд, хэвийн өсөлт хөгжилд сөрөг нөлөө учруулах, хүүхдийг асран хамгаалах үндсэн үүргээ эс биелүүлэх зэрэг үйлдлийг хэлнэ.</p> <p>Бэлгийн зүй бус харьцаа нь бэлгийн хүчирхийллийн бүхий л хэлбэрийг агуулах бөгөөд цус ойртуулах, эрт албадан гэрлүүлэх, хүчиндэх, садар самуун порнографид татан оруулах, бэлгийн боол болгох зэрэг багтана. Түүнчлэн, бэлгийн зүй бус харьцаа гэдэгт хүүхдэд биед зохисгүйгээр хүрэх, биеийн хэсгийг ил гаргах, секс үг хэллэг ашиглан хүүхэдтэй харилцах, хүүхдэд порно дүрс бичлэг үзүүлэх зэрэг ч мөн адил хамаарна.</p>
<p>Бэлгийн мөлжлөг</p>	<p>Бэлгийн мөлжлөг гэдэг нь эмзэг байдал, эрх мэдлийн ялгаа, олж авсан итгэлээ бэлгийн зорилгодоо ашиглах эсвэл ашиглахаар завдахыг хэлнэ. Үүнд хэн нэгнийг бэлгийн мөлжлөгт ашиглах замаар мөнгө болон нийгэм, улс төрийн ашиг олох явдал хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй олон зүйл хамаарна.</p>
<p>Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг</p>	<p>Хуульд заасан тодорхой насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт оруулах нь бэлгийн зүй бус харьцаа бөгөөд гэмт хэрэг мөн.</p> <p>Хүүхдийг Ивээх Сан хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийг дараах байдлаар авч үздэг:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхэд өөрөө зөвшөөрсөн эсвэл эс зөвшөөрснөөс үл хамааран хүүхдийг бэлгийн харьцаанд оруулах нь бэлгийн зүй бус харьцаа болохын зэрэгцээ хүчин, зохисгүй халдлага гэх гэмт хэрэгт тооцогдоно. • Хүүхдийн амьдарч буй улс орон эсвэл зөрчил гарсан газрын хууль тогтоомжийн дагуу хүүхэд хуулийн зөвшөөрөх насанд хүрсэн, хүүхэд зөвшөөрснөөс үл хамааран хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох нь гэмт хэрэгт тооцогдоно. • Хүүхдийн амьдарч буй улс орон эсвэл зөрчил гарсан газрын хууль тогтоомжийн дагуу хүүхэд хуулийн зөвшөөрөх насанд хүрсэн, түүнчлэн хүүхэд өөрөө зөвшөөрсөн ч гэсэн 18 нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орохыг хуулийн дагуу гэмт хэрэгт тооцохгүй ч Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, Ёсзүйн дүрмийн зөрчил гэж үзэн, зохих арга хэмжээг авна.
<p>Бодлогын хамрах хүрээ</p>	<p>Хүүхдийн аюулгүй байдлыг хангах энэхүү бодлого нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн бүх ажилтан, бүтэн болон хагас цагаар ажиллаж буй хүмүүс, гэрээт судлаач, зөвлөх гэх мэт манай байгууллагатай холбоотой бүхий л хүнд хамаатай. Тодруулбал:</p> <ul style="list-style-type: none"> • Бүх ажилтан • Сайн дурынхан, итгэмжит төлөөлөгчид, удирдах зөвлөлийн гишүүд, түнш байгууллага, холбоодын ажилтнууд, тэдгээрийн

	<p>төлөөлөгчид, “түнш, түнш байгууллагын ажилтан” гэдэг ойлголтод хамаарах Японы Хүүхдийг Ивээх Сантай албан ёсны болон гэрээт харилцаатай хүүхэдтэй ажилладаг байгууллага, бүлэг, хувь хүмүүс (хэрэв түнш байгууллага Хүүхдийн аюулгүй байдлыг хангах өөрийн байгууллагын бодлогыг мөрдөхөөр албан ёсоор зөвшилцсөнөөс бусад тохиолдол)</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхэдтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа явуулахаар Хүүхдийг Ивээх Сангийн оффис болон хөтөлбөртэй танилцаж буй хандивлагчид, сэтгүүлчид, олны танил хүмүүст энэхүү бодлого мөн хамаатай. Эдгээр хүнийг цаашид “төлөөлөгчид” гэж нэрлэнэ. • Дээр дурдсан бүх хүн ажил хэрэг болон хувийн амьдралын аль алинд энэхүү бодлогыг мөрдөх ёстой. <p>Бодлогыг зөрчсөн хэн бүхэнд сахилгын арга хэмжээ (ажлаас халах гэх мэт) авна. Түнш болон гэрээт байгууллага, түүний ажилтан бодлогыг зөрчсөн тохиолдолд гэрээ цуцлах болон шаардлагатай бусад арга хэмжээ авна. Шаардлагатай бол тухайн улсад мөрдөж буй хууль журмын дагуу арга хэмжээ авна.</p>
--	---

БҮЛЭГ 5. ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ

- **Удирдлага:** Бүх салбар, ажилтан өөрийн хүлээх үүрэг, хариуцлагаа сайтар ойлгох, энэхүү бодлого, ёсзүйн дүрэмд заасан зохимжтой зан үйлийг мөрдөхийг Японы Хүүхдийг Ивээх Сан шаарддаг. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх дотоод бүтэц бүрдүүлэхийн тулд Японы Хүүхдийг Ивээх Сан хүний нөөцийн оновчтой хуваарийг хэрэгжүүлэх бөгөөд Хүүхдийн аюулгүй байдлыг хангах хороог байгуулна. Энэхүү хороо нь байгууллага доторх болон гаднах орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой чадавхийг бэхжүүлэх зорилгоор стратегийн шийдлүүдийг гаргах, ахиц дэвшлийг хянах үүрэгтэй. Харин удирдах зөвлөл нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээх бөгөөд тэд аливаа асуудлын талаарх мэдээллийг хэлэлцэж, эцсийн шийдвэрийг гаргана.
- **Хөтөлбөрийн хэрэгжилт:** Аливаа хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхээс өмнө түүнийг хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаас нь хянан үзэх нь нэн чухал юм. Төсөл, үйл ажиллагааг төлөвлөх явцдаа учирч болох эрсдэл, авч болох арга хэмжээг урьдчилан тооцох ёстой. Түүнчлэн, төслийн хяналт, үнэлгээний явцад хүүхдийн аюулгүй байдлын асуудлыг системтэйгээр авч үзэх хэрэгтэй.
- **Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвсэлтэй тогтоосон холбоо:** Хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвслийн глобал сорилтуудын нэг билээ. Японы Хүүхдийг Ивээх Сан эвсэлтэй нягт холбоо тогтоож, үзэл бодол, түршлагаа хуваалцах бөгөөд тэдний хандлагыг үйл ажиллагаандаа баримтална. Японы Хүүхдийг Ивээх Сан энэхүү сорилтын хүрээнд суралцагч, тэргүүлэгч байгууллага байхыг ямагт эрмэлзэнэ.

БҮЛЭГ 6. ХОЛБОГДОХ БУСАД БИЧИГ БАРИМТ

- **Хүүхдийн аюулгүй байдлыг хангах протоколь:** Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвсэл Хүүхдийг аюулгүй байдлыг хангах протоколийг удирдах зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар баталсан байдаг. Бүх хэлбэрийн зүй бус харьцаа, бэлгийн мөлжлөгөөс үйлчилгээ үзүүлж буй хүүхдүүдээ хамгаалах үүднээс Хүүхдийг Ивээх Сангийн хүлээсэн үүрэг амлалт, хийх ёстой үйл ажиллагааг энэхүү протокольд тусгасан байдаг. Тиймээс энэхүү протоколь нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад

шаардлагатай хамгийн гол баримт бичиг юм. Протокольд бидний зорилго, хүүхдийн өмнө өмнө хүлээсэн үүрэг амлалт, Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвсэл, түүний гишүүдийн баримтлах ёстой стандартууд, тэдгээрийн хүрээг тус тус тусгасан байдаг.

- **Ёсзүйн дүрэм:** Хүүхдийг Ивээх Санд ажиллаж буй хүн бүр хүлээн зөвшөөрөгдөх хийгээд үл хүлээн зөвшөөрөгдөх зан үйлийн загварыг харуулсан ёсзүйн дүрэм (Хавсралт 1)-ийг баримтлах ёстой. Удирдах зөвлөл, ажилтан, сайн дурынхны хэн ч гэсэн энэ талаар сургалтад хамрагдах, ёсзүйн дүрмийг мөрдөнө гэдгээ гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

Дээр дурдсан бичиг баримтаас гадна Японы Хүүхдийг Ивээх Сан холбогдох бусад журмыг боловсруулан гаргах бөгөөд ингэснээр хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах боломжтой болох бөгөөд улмаар хүүхдэд аюулгүй байгууллага байх зорилгодоо хүрнэ.

oooOOOooo

ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЁСЗҮЙН ДҮРЭМ

Хүүхдийг хамгаалах үүрэгтэй байгууллага болох Хүүхдийг Ивээх Сангийн ажилтны онцгой үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж, хүүхдийг бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны зүй бус харьцаа, үл хайхрах байдалд оруулахаас урьдчилан сэргийлэхүйц аюулгүй орчин бүрдүүлж ажиллана.

Би дараах зүйлийг хэзээ ч хийхгүй:

- 1) Хүүхдийг цохих, зодох, хүч хэрэглэх, биемахбодын хувьд зүй бус харьцах
- 2) Хүүхэдтэй биемахбодын хийгээд бэлгийн харьцаа тогтоох
- 3) Зүй бус эсвэл мөлжлөгийн шинжтэй байж болох харилцааг хүүхэдтэй тогтоох
- 4) Зохисгүй, гутаасан, зүй бус үг хэллэг хэрэглэн хүүхэдтэй харилцах, ийм өнгө аясаар зөвлөгөө өгөх, санал тавих
- 5) Хүүхэдтэй зүй бус байдлаар хандах, хүүхдийг хүчирхийллийн эрсдэлд оруулах
- 6) Бэлгийн дур сонирхлоо илэрхийлсэн, зохисгүй үйл хөдлөл гаргах, үзүүлэх
- 7) Хүүхдийн чадах зүйлийг өмнөөс нь хийх
- 8) Хүүхдийг эсрэг хууль бус, аюултай, хүчирхийллийн шинжтэй аливаа үйл ажиллагаанд оролцох
- 9) Айлгаж ичээх, доромжлон гутаах, дорд үзэх байдлаар хүүхдэд хандах, сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл үйлдэх
- 10) Хүүхдийг ялгаварлан гадуурхах, бусдаас өөрөөр хандах, онцгойлон харж үзэх
- 11) ХИС-гийн хөтөлбөр, үйл ажиллагаанаас гадуур хүүхдүүдтэй хувийн холбоо харилцаа тогтоох
- 12) Ажиллаж буй хүүхэдтэйгээ нэг оронд унтах
- 13) Онцгой нөхцөл гараагүй байхад эсвэл удирдах ажилтны зөвшөөрөлгүйгээр хүүхэдтэй хамт нэг өрөөнд хонох
- 14) Садар самуун, хүчирхийллийг сурталчилсан зураг, кино, цахим хуудас хүүхдэд үзүүлэх
- 15) Өөрийгөө ёсзүйн дүрмийг зөрчсөн гэх аливаа таамаг сэжигт өртөх нөхцөл байдлыг бий болгох.

Би дараах зүйлийг хийнэ:

- 16) Эрсдэл учруулж болох нөхцөл байдлыг ойлгож, зохицуулах
- 17) Эрсдэлийг бууруулах үүднээс ажил үүрэг болон ажлын байраа төлөвлөх, зохицуулах
- 18) Хүүхэдтэй ажиллахдаа бусдад харагдахуйц байх орчныг бүрдүүлэхэд ямагт анхаарах
- 19) Санаа зовоосон аливаа асуудлыг нээлттэй ярилцах, хэлэлцэх соёлыг бий болгох
- 20) Ажилтнуудыг хариуцлагажуулах замаар хүчирхийллийн шинжтэй зан үйл, сөрөг дадлыг арилгах
- 21) Ажилтнууд болон бусад хүмүүс хүүхэдтэй хэрхэн харилцаж буйг хүүхдээс өөрөөс нь асууж тодруулах, хүүхдийн санааг ямар нэгэн зүйл зовоож байвал түүнийгээ илэрхийлэхийг нь дэмжих
- 22) Хүүхэдтэй түүний эрх, юу хийж болох, юу хийж болохгүй, ямар нэг асуудал гарвал юу хийх гэх мэтээр ярилцах замаар хүүхдийг чадавхижуулах.